



ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭСАНТ АЗЗА ТӨХК- ИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Аудитын газрын дарга, тэргүүлэх
аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70272582
Факс: 01-272-22582
И-мэйл: Jargalsaihan_tuv@yahoo.com

Төв аймгийн аудитын газар
Төв аймаг, Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Ихмонгол хөлөг Аудит” ХХК
Утас: 70001778
Web: www.imkaudit.mn

Захирал: С.Тунгалаг
Утас: 99061771
И-мэйл: tungalag.s@imkaudit.mn

Аудитын багийн ахлагч:
Аудитор: Д.Отгонсүрэн
И-мэйл: otgonsuren.d@imkaudit.mn

АУДИТЫН КОД:
ТӨАГ/2015/94/СТА-ТӨХК

АУДИТЫН ТАЙЛАН

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан
Хавсралт 5: Тодруулга

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ТӨАГ/2015/94/СТА-ТӨХЭ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС -тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2014 оны жилийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 2 дүгээр сарын 25 -наас 2015 оны 3 дугаар сарын 15-ныг хүртэл хийхээр төлөвлөн “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ын аудитын багийн гишүүн аудитор Д.Пүрэвжаргал, туслах аудитор Х.Болор-Эрдэнэ, аудиторын туслах Г.Ариунбат нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2014 оны жилийн санхүүгийн тайланг 2015 оны 2 дүгээр сарын 25-нд “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК-нь аудитыг 2015 оны 2 дүгээр сарын 25-наас 2015 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 3 дугаар 15-нд “Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь Компанийн тухай, Төсвийн тухай хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай, НББ-ийн тухай хууль, ХХОАТ-ын тухай хууль, ААНБОАТ-ын тухай, НӨАТ-ын тухай, Авто замын тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, НД-ын болон бусад хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Автозамын тухай хуулийн 15 дүгээр зүйлийн 15.1.1-д “Авто тээврийн хэрэгсэл саадгүй зорчиход авто замыг бэлэн байлгах”, Компанийн дүрмийн 2.1-д “Төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалтыг төрийн захиргааны байгууллагатай байгуулсан “Зам засвар, арчлалтын гэрээн”-ний дагуу Архангай аймгийн хэмжээнд зохион байгуулж, түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүргийг бүрэн хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Компанийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 76.1.8-д ТУЗ-нь “Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний ТӨАГ/2015/94/СТА-ТӨХК

бүрэн эрхийг тогтоох”, 76.1.9-д “ Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл , түүнд олгох шагнал урамшуулал,хариуцлагын хэмжээг тогтоох”, 83.1-д “ Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон/ ТУЗ байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тумын үйл ажиллагааг удирдана”, 83.3.3-д “ Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд гүйцэтгэх захирал байна” гэж заасны дагуу Д.Батсүх нь Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн захирлын үүргийг гүйцэтгэж байна. Эрдэнэсант АЗЗА ТӨХК-тай холбоотой хууль эрх зүйг баримтыг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Эрдэнэсант АЗЗА ТӨХК –ийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс компанийн гүйцэтгэх удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 2-ыг хийж гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Эрдэнэсант АЗЗА ТӨХК –ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС-тай бүрэн нийцэхгүй байна.Санхүүгийн тайланг бэлтгэсэн программ нь СТОУ-ын стандарттай уялдсан байна.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК –д ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Эрдэнэсант АЗЗА ТӨХК –ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь СТОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Компани нь ТУЗ-өөс баталсан Төлөвлөгөөний дагуу арилжааны банкна дахь харилцах дансаар болон байгууллагын кассаар үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлж, үйл ажиллагаагаа санхүүжүүлэн гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан байна.

Компанийн гүйцэтгэх удирдлага нь нь 2014 онд 4,068.7 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлоготой, 3,884.8 сая төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний

өртөг, 114.7 сая төгрөгийн удирдлага, борлуулалтын, 42.5 сая төгрөгийн, нийт 4,042.0 сая төгрөгийн зардалтай 19.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл:

Шилэн дансны тухай хуулийн дагуу Сангийн яамнаас зохион байгуулсан Шилэн дансны тухай хуулийн талаарх сургалтанд хамрагдаж, гарын авлага материал авч 2015 оны төсвийн төлөвлөгөөний талаарх мэдээллийг цахим хуудсанд оруулсан.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 172 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 30 горим, сорил гүйцэтгэв. (ТБА-СТА-В-5- аас үзнэ үү)

Үр дагавар: Доорх зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Зам тээврийн Яам, Хөгжлийн банк нь, Эрдэнэсант АЗЗА ТӨХК-тай Лүн, Эрдэнэсант, Арвай хээрийн 6.9 км, 2,636,000,000.00 төгрөгийн төсөвтэй замын ажлын гүйцэтгэгчийн гэрээ байгуулсан байна. Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь уг орлого түүнтэй холбогдох НӨАТ-ыг санхүүгийн тайланд туслан гүйцэтгэгчид өгөх өглөгөөр бүртгэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 5.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурель сууриар хөтөлнө”, 2 дугаар бүлгийн 9.1 “Аж ахуйн нэгж байгууллага нь хөрөнгө өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж бүртгэнэ” заалтуудыг зөрчсөн нь хууль, журмыг мөрдөхгүй байх.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Эрдэнэсант АЗЗА ТӨХК –ийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 0.2 сая төгрөгөөс дээш дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний 5,104.0 сая төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол шийдвэргүйгээр эзэмшигчийн өмчийн дансыг 372.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Шийдвэрлэсэн: 1. Компанийн дүрмийн 3.1, Компанийн тухай хуулийн заалтуудыг мөрдөж, эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулах талаар зөвлөмж өгөв.

2. Үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийн дүнгээр эзэмшигчийн өмчийн бусад хэсэг дансыг 219.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэсэн байна..

Шийдвэрлэсэн: НББОУС-20, Сангийн Сайдын 2013 оны 77-р тушаалын дагуу санхүүгийн тайланд залруулав.

ТӨАГ/2015/94/СТА-ТӨХК

3. Санхүүгийн тайлангийн программ хангамжийн алдаанаас мөнгөн гүйлгээний тайлангийн борлуулалтын орлогын дүн, орлого үр дүнгийн тайлангийн борлуулалтын орлогоос дүнгээс 1,575.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн программ хангамж нийлүүлэгч компаниар программын тохируулга хийлгэн санхүүгийн тайланд залруулав.

4. Конторын 29,6 төгрөгийн засварын ажлыг гүйцэтгэж дууссан боловч дуусаагүй барилгаар бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Эрх бүхий байгууллагын хүлээн авсан баримтыг бүрдүүлэн үндсэн хөрөнгийг капиталжуулах зөвлөмж өгөв.

5. Компанийн захирал Д.Батсүх нь өөрийн компанийн санхүүгийн хүндрэлтэй байдлыг зохицуулах зорилгоор 40,0 сая төгрөгийг, хүүгүйгээр хувиасаа зээлдүүлсэн нь компанийн тухай хуулийн 89.1-р заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Компанийн тухай хуулийн 89.1-р заалт „Хувь хүний Орлогын албан татварын хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

6. Зам тээврийн Яам, Хөгжлийн банк нь, Эрдэнэсант АЗЗА ТӨХК-тай Лүн, Эрдэнэсант „Арвай хээрийн 2,636,0 сая төгрөгийн төсөвтэй 6.9 км замын ажлыг гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан байна. Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь орлогыг гэрээний дагуу борлуулалтын орлогоор бүртгээгүй Үйлсийн зам ХХК-д өгөх өглөгөөр бүртгэж, түүнтэй холбогдох 230,9 сая төгрөгийн НӨАТ-ыг санхүүгийн болон татварын тайланд тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн: 1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 5.1-д “ Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэль сууриар хөтөлнө”, 2 дугаар бүлгийн 9.1-д “ Аж ахуйн нэгж байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, гэж заасны дагуу 2,636,0 сая төгрөгийг санхүүжилтийг борлуулалтын орлогоор залруулан бүртгүүлэв.

Шийдвэрлэсэн: 2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 8.1.1-д “ Бараа , ажил, үйлчилгээг импортолсон буюу экспортолсон,түүнчлэн борлуулсан тухай бүрд ноогдуулна” заалтын дагуу 230,9 төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоог Үйлсийн зам ХХК-тай хийж, татварын байгууллагад тайлагнах тухай албан шаардлага өгөв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг бус алдаа тогтоогдоогүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй ажил, түүний санхүүжилтийг гэрээ хэлцлийн дагуу бүртгэл тайланд тусгах ажлыг хангалтгүй хэрэгжүүлж байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Аудитын явцад дараагийн аудитаар гэрээ хэлцлийн хариуцлага, хэрэгжилтийн талаар дахин шалгаж үзэх шаардлагатай гэж үзлээ.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,104.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 4,430.9 сая төгрөгийн алдааг залруулж , 442.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 230.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.

ТӨАГ/2015/94/СТА-ТӨХК

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2013 оны санхүүгийн тайланд Аймгийн аудитын газрын захиалгаар Ихмонгол хөлөг аудит ХХК-ийн хийсэн аудитаар 5,1 сая төгрөгийн 1 акт, 7 зөвлөмж өгсөн бөгөөд 5,1 сая төгрөгийн актыг бүрэн барагдуулж, 7 зөвлөмжийн 90 хувийг хэрэгжүүлж, биелэлтийг гарган ирүүлсэн байна.

Зөвлөмж:

Менежментийн захидал зөвлөмжийн талаар дэлгэрэнгүй тусгасан болно.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Л.ЖАРГАЛСАЙХАН/ Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

/О.АМАРЖАРГАЛ/ Огноо:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

/С.ТУНГАЛАГ/ Огноо: